

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

**Аудитлагдсан санхүүгийн тайлан**  
**2025 оны 12 дугаар сарын 31**



**Shape the future  
with confidence**

# ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

## Аудитлагдсан санхүүгийн тайлан

---

### Агуулга

	<b>Page</b>
Компаний талаарх мэдээлэл	1
Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл	2
Хараат бус аудиторын тайлан	3 – 4
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	5
Санхүүгийн байдлын тайлан	6
Өмчийн өөрчлөлтийн тайлан	7
Мөнгөн гүйлгээний тайлан	8
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	9 - 32

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**  
**Компаний талаарх мэдээлэл**

---

ТУЗ-ийн гишүүд

О. Батбаатар  
О. Мягмардорж  
Н. Батдорж

Нарийн бичиг

Б. Шүрэнцэцэг

Албан ёсны хаяг

Бага тойруу, 14 давхар  
Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,  
Улаанбаатар 14200, Монгол Улс

Хараат бус аудитор

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК  
Мэргэшсэн нягтлан бодогчид

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**

**Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл**

---

Ди Би Эм Лизинг ХХК-ийн (цаашид “Компани” гэх) Гүйцэтгэх захирал Нацагдоржын Цэрэнсодном болон Нягтлан бодогч Золжаргалын Авирмэд, бид Компанийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



**Золжаргалын Авирмэд**  
Нягтлан бодогч

Улаанбаатар хот, Монгол улс

Огноо: 2026 оны 3 сарын 31



Shape the future  
with confidence

Ernst & Young Mongolia Audit LLC  
15/F, Altan Joloo Tower  
Seoul Street 13/A  
Ulaanbaatar 14252  
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005  
ey.com

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Ди Би Эм Лизинг ХХК-ий хувьцаа эзэмшигчдэд

### Дүгнэлт

Бид Ди Би Эм Лизинг ХХК (“Компани”)–ий 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компаний санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компаний санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)–өөс баталж гаргасан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)–уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

### Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу бэлтгэх, бодитойгоор илэрхийлэх ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсхүл татан буулгахаар төлөвлөсөн эсхүл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

### Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”–ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсхүл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”–ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.



Shape the future  
with confidence

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Ди Би Эм Лизинг ХХК-ий хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

### Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь бодитой илэрхийлэгдэх шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг.

Энэхүү хараат бус аудиторын тайланг гаргаж буй аудитын гэрээт ажлын партнер нь Доржбатын Мандахбаяр болно..

### Бусад зүйл

2024 оны 12 дугаар сарын 31-нээрх дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлангуудад өөр аудитын компани аудит хийж 2025 оны 3 дугаар сарын 15-ны өдөр СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв хэмээн дүгнэсэн болно.

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компаний хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компаний хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

*Ernst & Young Mongolia Audit LLC*  
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК  
Мэргэшсэн нягтлан бодогчид  
УЛААНБААТАР ХОТ  
ДОРЖБАТЫН МАНДАХБАЯР  
Партнер

Монгол улс, Улаанбаатар хот  
Огноо: 2026 оны 3 дугаар сарын 31

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**

**Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан**

**2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн**

	<b>Тод.</b>	<b>2025</b> <b>мян.төг</b>	<b>2024</b> <b>мян.төг</b>
Хүүгийн орлого	<b>4</b>	14,469,180	10,775,986
Үйл ажиллагааны зардал	<b>5</b>	(1,894,390)	(1,724,708)
Бусад (зардал)/ орлого, цэвэр	<b>6</b>	<u>(4,915,782)</u>	<u>(640,730)</u>
<b>Үйл ажиллагааны орлого</b>		<b>7,659,008</b>	<b>8,410,548</b>
Зээлийн үнэ цэний хүлээгдэж буй алдагдалын сан	<b>7</b>	<u>341,990</u>	<u>(3,855,088)</u>
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>8,000,998</b>	<b>4,555,460</b>
Орлогын татварын зардал	<b>8</b>	<u>(1,257,352)</u>	<u>(902,723)</u>
<b>Тайлант жилийн цэвэр ашиг болон нийт дэлгэрэнгүй орлого</b>		<b><u>6,743,646</u></b>	<b><u>3,652,737</u></b>

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.*

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК****Санхүүгийн байдлын тайлан****2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх**

	<b>Тод.</b>	<b>2025 мян.төг</b>	<b>2024 мян.төг</b>
<b>ХӨРӨНГӨ</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	<b>9</b>	85,300,678	1,848,063
Хугацаатай хадгаламж	<b>10</b>	–	64,044,131
Дансны болон бусад авлага	<b>11</b>	23,167,463	28,781,656
Түрээсийн авлага	<b>12</b>	20,203,396	27,725,408
Бусад хөрөнгө		99	169
Үндсэн хөрөнгө	<b>13</b>	1,244,521	1,294,811
Биет бус хөрөнгө		2,811	3,731
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b><u>129,918,968</u></b>	<b><u>123,697,969</u></b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Дансны болон бусад өглөг	<b>14</b>	249,226	190,838
Орлогын албан татварын өглөг	<b>8</b>	216,708	797,743
<b>Нийт өр төлбөр</b>		<b><u>465,934</u></b>	<b><u>988,581</u></b>
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>			
Хувьцаат капитал	<b>15</b>	100,000,000	100,000,000
Хуримтлагдсан ашиг		29,453,034	22,709,388
<b>Нийт эздийн өмч</b>		<b><u>129,453,034</u></b>	<b><u>122,709,388</u></b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		<b><u>129,918,968</u></b>	<b><u>123,697,969</u></b>

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй нэг хэсэг болно.*

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**

**Өмчийн өөрчлөлтийн тайлан**

**2025 ны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн**

	<b>Хувьцаат капитал мян.төг (Год. 15)</b>	<b>Хуримтлагдсан ашиг мян.төг</b>	<b>Нийт мян.төг</b>
<b>2024 оны 1-р сарын 1-ний байдлаар</b>	100,000,000	19,056,651	119,056,651
Нийт бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх тайлант жилийн ашиг	–	3,652,737	3,652,737
<b>2024 оны 12-р сарын 31 болон 2025 оны 1-р сарын 1-ний байдлаар</b>	<b>100,000,000</b>	<b>22,709,388</b>	<b>122,709,388</b>
Нийт бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх тайлант жилийн ашиг	–	6,743,646	6,743,646
<b>2025 оны 12-р сарын 31-ний байдлаар</b>	<b>100,000,000</b>	<b>29,453,034</b>	<b>129,453,034</b>

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.*

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**

**Мөнгөн гүйлгээний тайлан**

**2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн**

	Тод.	2025 мян.төг	2024 мян.төг
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>Татварын өмнөх ашиг</b>		8,000,998	4,555,460
<i>Тохируулууд:</i>			
Хүүгийн орлого	4	(13,856,358)	(10,775,986)
Данснаас хассан түрээсийн авлагын алдагдал	6	4,924,284	–
Ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй гарз/(олз), цэвэр	6	(9,590)	54,491
Үндсэн хөрөнгийн элэгдэл	5	80,200	67,180
Биет бус хөрөнгийн хорогдуулга	5	920	921
Зээлийн үнэ цэний хүлээгдэж буй алдагдалын сан	7	(341,990)	3,855,088
<b>Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны алдагдал</b>		<b>(1,201,536)</b>	<b>(2,242,846)</b>
<i>Үйл ажиллагааны хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлтүүд:</i>			
Дансны болон бусад авлага		6,363,501	3,437,461
Түрээсийн авлага		(61,536)	12,930,626
Бусад хөрөнгө		70	47
Дансны болон бусад өглөг		58,387	(98,382)
<b>Үйл ажиллагаанаас олсон мөнгөн гүйлгээ</b>		<b>5,158,886</b>	<b>14,026,906</b>
Төлсөн орлогын албан татвар	8	(1,838,387)	(1,124,074)
Хүлээн авсан хүүгийн орлого		17,152,436	7,924,569
<b>Үндсэн үйл ажиллагаанаас олсон цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>20,472,935</b>	<b>20,827,401</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Хугацаатай хадгаламжийн дуусгавар болох үед хүлээн авсан		162,650,000	14,599,940
Хугацаатай хадгаламж байршуулсан		(99,650,000)	(63,000,000)
Үндсэн хөрөнгийн худалдан авалт		(29,910)	(48,782)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас хүлээн авсан/(-нд зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>62,970,090</b>	<b>(48,448,842)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)</b>		<b>83,443,025</b>	<b>(27,621,441)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9	1,848,063	29,472,243
Гадаад валютын ханшийн хэлбэлзлийн бэлэн мөнгөнд үзүүлэх нөлөө		9,590	(2,739)
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>9</b>	<b>85,300,678</b>	<b>1,848,063</b>

*Хавсаргасан тодруулууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй нэг хэсэг болно.*

## 1. Компанийн талаарх мэдээлэл

Ди Би Эм Лизинг ХХК (цаашид “Компани” гэх) нь 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсад үүсгэн байгуулагдсан. Компанийг Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК бүрэн эзэмшдэг. Компанийн албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Бага тойруу, 14 дүгээр давхар.

Компани нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд бөгөөд Монгол Улсын санхүүгийн түрээсийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхэлдэг. Компани нь дунд болон урт хугацаатай гэрээний дагуу санхүүгийн түрээсийг олгодог. Компани нь Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогод багтсан Монгол Улсын хөгжилд стратегийн чухал ач холбогдолтой салбаруудын төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахыг зорин ажилладаг.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангууд нь Компанийн гүйцэтгэх удирдлагын тушаалаар 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр батлагдан гарсан.

## 2. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд

### 2.1 Тайлан бэлтгэх үндэслэл ба нийцлийн мэдэгдэл

Компанийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталж гаргасан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэгдсэн болно.

Санхүүгийн тайлангууд нь түүхэн өртгийн зарчмаар бэлтгэгдсэн бөгөөд санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр мянгачилан тайлагнав.

Компанийн санхүүгийн тайлан нь тасралтгүй үйл ажиллагааны зарчмаар бэлтгэгдсэн болно.

### 2.2 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Компанийн санхүүгийн тайланг гаргах өдрөөр батлагдсан боловч хүчин төгөлдөрөөр хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон стандартын тайлбаруудыг дор харуулав. Компани нь эдгээр стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх үеэс дагаж мөрдөнө.

- |  |  |
|--|--|
| • СТОУС 18                                 | <i>Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга<sup>1</sup></i>                               |
| • СТОУС 19                                 | <i>Олон нийтэд хамааралгүй охин компаниуд: Тодруулга<sup>1</sup></i>                           |
| • СТОУС 9 болон СТОУС 7-ын нэмэлт өөрчлөлт | <i>Санхүүгийн хэрэглүүрийн ангилал болон үнэлгээний нэмэлт өөрчлөлт<sup>2</sup></i>            |
| • СТОУС 9 болон СТОУС 7-ын нэмэлт өөрчлөлт | <i>Байгалиас хамааралтай цахилгаан эрчим хүчний гэрээ<sup>2</sup></i>                          |
| • СТОУС-ын сайжруулалт                     | <i>Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын тухай жилийн сайжруулалт 11<sup>2</sup></i> |

<sup>1</sup>2027 оны 1-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.

<sup>2</sup>2026 оны 1-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ

## СТОУС 18 – Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга

2024 оны 4-р сард, НББЗ-өөс НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”-ыг орлох СТОУС 18 “Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга”-ыг баталсан. СТОУС 18 нь Ашиг, алдагдлын тайлангийн тодорхой нийт дүн болон бүлгийн дүнг заасан толилуулгатай холбоотой шинэ шаардлагуудыг тодорхойлсон. Түүнчлэн, компани нь ашиг алдагдлын тайлан дахь бүх орлого болон зардлуудыг дараах таван бүлгийн аль нэгэнд ангилах шаардлагатай болсон. Үүнд: үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүжилтийн, орлогын албан татварын болон зогсоосон үйл ажиллагааны гэсэн бүлгүүд хамаарах бөгөөд эхний гурван бүлгийн шинээр нэвтрүүлсэн.

Мөн уг стандарт нь менежментийн тодорхойлсон гүйцэтгэлийн шинэ үзүүлэлтүүдийг ил тод мэдээлэхийг шаарддаг. Эдгээр нь орлого, зардлын бүлгийн дүнг агуулдаг бөгөөд үндсэн санхүүгийн тайлан болон тодруулгад гүйцэтгэх үүргийг тодорхойлсны үндсэн дээр санхүүгийн мэдээллийг нэгтгэх болон задлах шинэ шаардлагуудыг тусгасан.

СТОУС 7 Мөнгөн гүйлгээний тайланд цар хүрээ багатай өөрчлөлтүүд орсон бөгөөд үүнд шууд бус аргаар үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тодорхойлохдоо эхлэх цэгийг ‘цэвэр ашиг, алдагдал’-аас ‘үйл ажиллагааны ашиг, алдагдал’ болгон өөрчилсөн. Мөн хүү болон ногдол ашгийн мөнгөн гүйлгээг ангилахтай холбоотой сонголтыг халсан. Үүнээс гадна бусад хэд хэдэн стандартад дагалдах өөрчлөлтүүд орсон.

СТОУС 18 болон бусад стандартын өөрчлөлтүүд нь 2027 оны 1-р сарын 1-ний өдрөөс эсхүл түүнээс хойших тайлант жилүүдэд хүчин төгөлдөр болно. Гэхдээ хугацаанаас нь өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрөх бөгөөд хэрэгжүүлсэн тохиолдолд үүнийг тайланд тусгайлан толилуулах шаардлагатай. СТОУС 18-ийг өмнөх тайлант хугацаанд буцаан мөрдөнө.

Компани нь уг стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор санхүүгийн тайлангууд болон бусад холбогдох тодруулгуудад үзүүлэх нөлөөллийг тодорхойлохоор ажиллаж байна.

Компани нь бусад шинэ стандарт болон нэмэлт өөрчлөлтүүд нь компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөөгүй гэж үзэж байна.

### **2.3 Шинэ, шинэчлэгдсэн стандартууд болон тайлбарууд**

Компани нь батлагдсан боловч одоогоор хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээгүй шинэ стандартууд, нэмэлт өөрчлөлтүүд болон тайлбаруудыг урьдчилан мөрдөөгүй болно.

2025 онд анх удаа хэрэгжиж эхлсэн бусад стандартууд, нэмэлт өөрчлөлтүүд болон тайлбарууд нь Компанийн санхүүгийн тайланд нөлөө үзүүлээгүй бөгөөд эдгээрийг доор харуулав:

- НББОУС 21-ын нэмэлт өөрчлөлт *Валютын хөрвөх чадварын дутмаг байдал*

### **2.4 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд**

#### **Гадаад валютын ханшийн тэгшитгэл**

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ хийгдсэн өдрийн валютын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг санхүүгийн тайлангийн өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг.

Бодит үнэ цэнээр хэмжигддэг, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг. Түүхэн өртгөөр хэмжигддэг, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлж тайлагнадаг.

Ханшийн тэгштгэлийн аливаа зөрүүг тухайн жилийн ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

#### **Орлого болон зардлыг хүлээн зөвшөөрөх**

Хүүгийн орлого болон зардлыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг. “Үр ашигт хүү” гэдэг нь хүлээгдэж буй хугацаан дах ирээдүйд төлөгдөх буюу хүлээн авах мөнгөн урсгалыг санхүүгийн хэрэглүүрийн дансны үнэд дискаунтчилахад ашиглаж буй хүү юм:

- санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ; эсвэл
- санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг.

Худалдан авсан эсвэл үүсгэн бий болгосон, түрээсийн үнэлэмж буурсан санхүүгийн хөрөнгөөс бусад санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшнийг тооцоолохдоо Компани нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцөлийн дагуу ирээдүйн бүх мөнгөн урсгалыг тооцох боловч хүлээгдэж буй алдагдлыг тооцохгүй. Худалдан авсан эсвэл үүсгэн бий болгосон, түрээсийн үнэлэмж буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд түрээсийн тохируулсан үр ашигт хүүгийн түвшнийг тооцон хүлээгдэж буй алдагдлын ирээдүйн мөнгөн урсгалыг тооцно.

Үр ашигт хүүгийн тооцоололд гүйлгээний зардал, хураамж, төлбөр хийсэн эсвэл хүлээн авсан хугацаа зэрэг үр ашигт хүүгийн чухал хэсгүүд багтана. Гүйлгээний зардалд санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг худалдан авах болон борлуулахтай шууд хамаарах нэмэгдэл зардал багтана.

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн ‘хорогдуулсан өртөг’ нь санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үндсэн төлөлтийг хасаж, үр ашигт хүүгийн түвшнийг ашиглан анхны болон эцсийн дүнгийн зөрүүгээр хуримтлагдсан хорогдуулгыг нэмэх эсвэл хасах ба санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй аливаа хүлээгдэж буй түрээсийн алдагдлын санг тохируулсан дүнг хэлнэ.

Хорогдуулсан өртгөөр хэмжигддэг ‘санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ’ нь хүлээгдэж буй аливаа түрээсийн алдагдлын санг тохируулснаас өмнөх санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийг хэлнэ.

#### **Санхүүгийн хэрэглүүр – Анх хүлээн зөвшөөрөх болон дараа үеийн хэмжилт**

Санхүүгийн хэрэглүүр нь нэг компанийн санхүүгийн хөрөнгө, өөр компанийн санхүүгийн өр төлбөр эсхүл эздийн өмчийг нэмэгдүүлдэг аливаа гэрээг хэлнэ.

***Санхүүгийн хөрөнгө***

*Анх хүлээн зөвшөөрөх болон хэмжилт*

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө дараагийн хэмжилтийг хорогдуулсан өтгөөр бүртгэх, бодит үнэ цэний (БҮЦ) өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх, БҮЦ-ийн өөрчлөлт нь ашиг, алдагдалд бүртгэгдэх гэж ангилна.

Санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн ангилал нь гэрээний нөхцөл болон бизнес загвар дээр үндэслэнэ.

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

### Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр эсвэл БҮЦ-ийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэхийн тулд, санхүүгийн хөрөнгүүдийн гэрээний нөхцөл нь тодорхой үед үлдэгдлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн мөнгөн гүйлгээг нэмэгдүүлдэг байна. Энэхүү шалгуурыг “Үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрийн шалгуур (ҮТХТ шалгуур)” гэх ба санхүүгийн хэрэглүүрийн түвшинд хийгдэнэ. ҮТХТ шалгуур хангаагүй хэрэглүүрийг, бизнес загвараас үл хамааран, БҮЦ-ийн өөрчлөлтийг ашиг, алдагдлаар бүртгэгдэх хэрэглүүр гэж ангилна.

Компанийн бизнес загвар нь санхүүгийн хэрэглүүрээс мөнгөн урсгал бий болгож буй арга барилыг илэрхийлнэ. Бизнес загвар нь мөнгөн урсгалыг хэрхэн бий болж байгааг тодорхойлох ба үүнд гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулснаар, санхүүгийн хэрэгслийг борлуулснаар, эсвэл хосолсон хэлбэрээр байна. Хорогдуулсан өртгөөр ангилж, хэмждэг санхүүгийн хэрэглүүрүүд нь гэрээний дагуу мөнгөн гүйлгээ хүлээн авах зорилготой бизнесийн загварт хамаардаг бол БҮЦ-ийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэж хэмждэг санхүүгийн хэрэглүүрүүд нь гэрээний дагуу мөнгөн гүйлгээ хүлээн авах мөн тэдгээрийг борлуулах хосолсон бизнесийн загварт хамаарна.

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт нь арилжааны өдөр буюу Компанийн тухайн хэрэгслийн гэрээний оролцогч тал болсон өдрөөр хийгдэнэ. Үүнд зах зээлийн зохицуулалт эсвэл журмаар тогтоосон хугацаанд хөрөнгийг нийлүүлэхийг шаарддаг санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл борлуулах ердийн арилжаа багтана.

#### *Хорогдуулалтын өртгөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгө*

Хорогдуулсан өртгөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгүүд нь бүртгэснээс хойш үр ашигт хүүгээр хэмжигддэг ба үнэ цэний бууралт мөн тооцогдоно.

Компанийн хорогдуулалтын өртгөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгөд банкны хадгаламж, түрээсийн болон гуравдагч талаас авах авлагууд багтаж байна.

#### *Бүртгэлээс хасах*

Санхүүгийн хөрөнгө (эсвэл санхүүгийн хөрөнгийн тодорхой хэсэг, эсвэл түүнтэй ижил төрлийн санхүүгийн хөрөнгийн багцийн нэг хэсэг)-ийг дараах тохиолдолд данснаас хасна. Үүнд:

- Мөнгөн урсгал хүлээн авах эрх дуусгавар болсон үед, эсвэл
- Компани тухайн санхүүгийн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн, эсвэл “дамжуулан төлөх” зохицуулалтын дагуу хүлээн авсан мөнгөн урсгалыг сааталгүйгээр гуравдагч талд бүрэн хэмжээгээр төлөх үүргийг хүлээсэн, эсвэл (а) Компани тухайн хөрөнгийн бүх эрсдэл, өгөөжийг шилжүүлсэн, эсвэл (б) Компани тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл, өгөөжийг шилжүүлээгүй болон хадгалж үлдээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн

Компани аливаа хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн бол тус хөрөнгөтэй холбоотой аливаа эрсдэл болон өгөөжийг авч үлдсэн эсэхийг үнэлж үзнэ. Хэрэв Компани уг хөрөнгийн ихэнх эрсдэл болон өгөөжийг шилжүүлээгүй эсвэл авч үлдээгүй тохиолдолд Компани хөрөнгийг уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцооор байх хэмжээгээр нь үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Компани холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Компанийн хадгалж үлдсэн эрх, үүргийн хэмжээнд хэмжигдэнэ.

Үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Компанийн төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

#### *Санхүүгийн хөрөнгийн үнэ цэний бууралт*

*“Зээлийн үнэ цэний хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)” аргын ерөнхий ойлголт*

Компани нь Зээлийн үнэ цэний хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)-ын санг дараах санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хүлээн зөвшөөрдөг:

- хорогдуулсан өртгөөр нь хэмжигддэг санхүүгийн хөрөнгө; ба
- санхүүгийн түрээсийн авлагууд.

ЗҮЦХА санг, анх бүртгэснээс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт ажиглагдсан тохиолдолд хөрөнгийн нийт хугацаанд үүсэхээр хүлээгдэж буй зээлийн үнэ цэний алдагдал дээр үндэслэн бүртгэнэ. Харин анх бүртгэснээс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гараагүй тохиолдолд зөвхөн дараагийн 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн үнэ цэний алдагдал дээр үндэслэн бүртгэнэ. Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлох Компанийн бодлогыг Тодруулга 18-т тусгасан.

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

### Санхүүгийн хэрэглүүр – Анх хүлээн зөвшөөрөх болон дараа үеийн хэмжилт (үргэлжлэл)

#### Санхүүгийн хөрөнгийн үнэ цэний бууралт (үргэлжлэл)

*“Зээлийн үнэ цэний хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)” аргын ерөнхий ойлголт (үргэлжлэл)*

Ирээдүйн 12 сарын ЗҮЦХА нь нийт хугацааны ЗҮЦХА аргын нэг хэсэг байх бөгөөд тайлагналын өдрийн дараах 12 сард санхүүгийн хэрэглүүрийн чанаргүйдлийн магадлалын үр дүнгээр ЗҮЦХА-г илэрхийлнэ.

Санхүүгийн хэрэглүүрийн үндсэн багцаас шалтгаалан нийт хугацааны ЗҮЦХА болон ирээдүйн 12 сарын ЗҮЦХА-г тусгай болон бүлгийн үнэлгээгээр тооцоолно.

Компани нь үнэлгээ хийх журмыг тодорхойлсон бөгөөд тайлант үеийн эцэс бүрд санхүүгийн хэрэглүүрийн үлдэх хугацаанд үүсэж болох эрсдэлийн өөрчлөлтийг харгалзан санхүүгийн хэрэглүүрийг анх бүртгэснээс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг харгалзан авч үзнэ.

Дээр дурдсан процесс дээр тулгуурлан, доор дурдсанаар Компани санхүүгийн хөрөнгүүдийг шатлал 1, шатлал 2, шатлал 3 болон Худалдан авах үед үнэ цэнэ буурсан (ХАҮҮЦБ) хөрөнгө гэж ангилдаг.

Шатлал 1: Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед Компани нь 12 сарын ЗҮЦХА-г бүртгэнэ. Мөн шатлал 1-рүү зээлийн эрсдэл нь буурсан шатлал 2-ын зээлүүд дахин ангилагдана.

Шатлал 2: Анх хүлээн зөвшөөрсөн үеэс санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн үед Компани нь нийт хугацааны ЗҮЦХА-г бүртгэнэ. Мөн шатлал 2- рүү зээлийн эрсдэл нь буурсан шатлал 3-ын зээлүүд дахин ангилагдана.

Шатлал 3: Үнэ цэний бууралтад орсон санхүүгийн хөрөнгүүд багтана. Компани нь нийт хугацааны ЗҮЦХА-г бүртгэнэ.

ХАҮҮЦБ: ХААҮЦБ хөрөнгө нь анх хүлээн зөвшөөрөх үед үнэ цэнэ буурсан байсан санхүүгийн хөрөнгө юм. ХААҮЦБ хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр бүртгэх бөгөөд дараа үеийн хүүгийн орлогыг үнэ цэний бууралтаар тохируулсан үр ашигт хүүгээр тооцно. Тус хөрөнгийн хүлээгдэж буй зээлийн алдагдалд өөрчлөлт орсон тохиолдолд зөвхөн холбогдох ЗҮЦХА-г тэр хэмжээгээр нэмэгдүүлж эсвэл багасгана.

Компани нь санхүүгийн хөрөнгийг нийт үлдэгдэл эсвэл зарим хэсгийг төлөгдөх боломжгүй гэж үзвэл санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулна. Үүнийг санхүүгийн хөрөнгийн (хэсэгчилсэн) үл хүлээн зөвшөөрөлт гэнэ.

Банкны хадгаламж болон бусад авлагын хувьд Компанийн зүгээс зээлийн эрсдэл багатай гэж үзэх хялбарчилсан аргачлалыг хэрэглэдэг. Тайлант жилийн эцэс бүрд Компани тухайн хэрэгсэл зээлийн эрсдэл багатайд хамаарах эсэхийг үнэлэхдээ, хэт их зардал болон хүчин чармайлт гаргах шаардлагагүйгээр олж авах боломжтой бүхий л үндэслэлтэй, найдвартай мэдээллийг бүрэн ашиглан үнэлгээ хийдэг.

#### *ЗҮЦХА тооцоолол*

Компани нь үр ашигт хүүгээр хорогдуулсан хүлээгдэж буй мөнгөний дутагдлыг хэмжих магадлалын-жигнэсэн гурван хувилбараар ЗҮЦХА-г тооцоолдог. Мөнгөний дутагдал нь гэрээний дагуух мөнгөн гүйлгээ болон эргэн төлөгдөхөөр хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний зөрүү юм. ЗҮЦХА-ын тооцооллын үндсэн зарчим, механизмыг дараах хэсгүүдэд дэлгэрэнгүй тайлбарласан бөгөөд гол бүрэлдэхүүн элементүүд нь дараах байдлаар тодорхойлогдоно:

ЧМ: Чанаргүйдлийн магадлал (ЧМ) нь өгөгдсөн цаг хугацаанд төлбөрийн чадваргүй болох магадлалаар тооцоолно. Хэрвээ хэрэглүүр нь өмнө нь үл хүлээн зөвшөөрч байгаагүй мөн харгалзах багцад үргэлжлүүлэн байгаа бол үнэлсэн хугацааны тодорхой хугацаанд нэг удаа алдагдал үүсэх боломжтой.

ЧӨД: Чанаргүйдэлд өртөх дүн (ЧӨД) нь тайлагналын дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлт, гэрээний дагуух үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлт, зээлийн үүргийн хүрээнд нэмж олгосон дүн болон төлбөр хоцорсноор үүсэх хуримтлагдсан хүүг харгалзсан тооцоолол.

АХЧ: Алдагдалд хүргэх чанаргүйдэл (АХЧ) нь өгөгдсөн цаг хугацааны туршид чанаргүйдлийн үеийн алдагдлын тооцоолол юм. Энэ нь гэрээний дагуу мөнгөн урсгал болон зээлдэгч хүлээн авахаар тооцоолсон дүн, барьцаа хөрөнгө борлуулсан дүнгийн нийлбэрийн зөрүүнээс тооцно.

ЗҮЦХА тооцоолох үед Компани гурван хувилбарыг авч үздэг (суурь, эерэг болон сөрөг). Эдгээр нь өөр өөр ЧМ-д хамаарагдана.

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

### Санхүүгийн хэрэглүүр – Анх хүлээн зөвшөөрөх болон дараа үеийн хэмжилт (үргэлжлэл)

#### Санхүүгийн хөрөнгийн үнэ цэний бууралт (үргэлжлэл)

Зээлийн алдагдлыг тооцох хамгийн урт хугацаа нь санхүүгийн хэрэгслийн гэрээний хүчинтэй хугацаа бөгөөд Компанид тухайн хэрэгслийг хугацаанаас өмнө дуудан төлүүлэх хууль ёсны эрх байгаа тохиолдолд л энэ хугацаа богиносгож болно.

ЗҮЦХА-ын тооцооллын аргыг доор хураангуйлав:

Шатлал 1: Ирээдүйн 12 сарын ЗҮЦХА нь нийт хугацааны ЗҮЦХА загварын нэг хэсэг байх бөгөөд тайлагналын өдрийн дараах 12 сард санхүүгийн хэрэглүүрийн чанаргүйдлийн үр дүнгээр ЗҮЦХА-ыг илэрхийлнэ. Компани нь ирээдүйн 12 сарын ЗҮЦХА тайлагналын өдрөөс хойш 12 сарын дотор ЧМ-д үндэслэн тооцдог. ЧӨД-ийн урьдчилсан төсөөлөлд 12 сарын дотор хүлээгдэж буй ЧМ-ыг хэрэглэх бөгөөд хүлээгдэж буй АХЧ-аар үржүүлэгдэж анхны үр ашигт хүүтэй ойролцоо дүнгээр хорогдуулна.

Шатлал 2: Санхүүгийн хөрөнгө анх бүртгэснээс хойш тухайн хөрөнгө зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлттэй байгаа нь тогтоогдсон бол Компани нь нийт хугацааны ЗҮЦХА-ын сан байгуулан бүртгэнэ. Санг байгуулахдаа хэд хэдэн хувилбарууд дээр үндэслэн тооцоолох боловч ЧМ болон АХЧ-ыг нь нийт хугацаанд тооцоолж гаргана. Хүлээгдэж буй мөнгөний дутагдалыг үр ашигт хүүтэй ойролцоо хувиар хорогдуулна.

Шатлал 3: Үнэ цэнэ буурсан гэж үзсэн хөрөнгийн хувьд, Компани нь нийт хугацааны ЗҮЦХА-ыг бүртгэнэ. Энэ аргачлал нь Шатлал 2-т ашигласантай ижил аргачлалаар тооцогдох бөгөөд ЧМ-ыг 100% гэж үзнэ.

ХАҮҮЦБ: ХАҮҮЦБ хөрөнгө анх хүлээн зөвшөөрөх үед үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө юм. Компани нь зөвхөн анх хүлээн зөвшөөрсөн үеэс хойшх магадлалаар жигнэсэн гурван хувилбарыг зээлээр тохируулсан үр ашигт хүүгээр хорогдуулсан хуримтлагдсан нийт хугацааны ЗҮЦХА-г хүлээн зөвшөөрнө.

#### Ирээдүйн мэдээлэл

Компанийн ЗҮЦХА-ын загвар нь доор харуулсан эдийн засгийн өгөгдлүүд дээр суурилсан ирээдүйн мэдээлэл дээр тулгуурладаг:

- Дотоодын нийт бүтээгдэхүүний (“ДНБ”) өсөлт
- Ажилгүйдлийн түвшин
- Төгрөг/Ам.долларын ханш
- Инфляцын түвшин
- Үйлдвэрлэлийн нэмэгдэл өртөг (тогтмол үндсэн нэгжээр)
- Тээврийн үйлчилгээ (арилжааны үйлчилгээний экспортын %-ийн хувьд)
- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загас агнуурын нэмэгдэл өртөг (жилийн өсөлтийн %)
- Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ (нийт эцсийн эрчим хүчний хэрэглээний %)
- Хүдэр, металл экспорт (бараа бүтээгдэхүүний нийт экспортын %)

ЗҮЦХА-ыг тооцоололд ашиглаж буй мэдээлэл нь санхүүгийн тайлангийн өдрөөрх зах зээлийн бүх шинж тэмдгийг агуулаагүй байх магадлалтай. Эдгээр ялгаа нь мэдэгдэхүйц материаллаг үед зарим тохиолдолд чанарын тохируулгуудыг түр тохируулгаар хийдэг.

#### Санхүүгийн хэрэглүүрийг цэвэршүүлэх

Хэрэв Компани хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр тайланд толилуулах эрхтэй.

#### Данснаас хасах

Компани нь хөрөнгийн эргэн төлөлтийг зогсоосон үед санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн данснаас хасна. Хэрвээ данснаас хасах үнэ хуримтлагдсан сангаас их тохиолдолд, зөрүүгээр нь санг нэмэгдүүлж дараа нь дансны нийт үнийн дүнг бууруулна. Дараах үеийн эргэн төлөлтүүд нь эрсдэлийн сангийн зардлыг зардлыг бууруулна.

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

### Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Санхүүгийн байдлын тайлан дээрх мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, банк санхүүгийн байгууллага дахь харилцах данс болон 3 сар ба түүнээс бага хугацаатай, хөрвөх чадвар өндөртэй хадгаламжуудыг хамруулна. Эдгээр нь богино хугацааны мөнгөн төлбөрийн хэрэгцээг хангах зорилготой, бэлэн мөнгө рүү шууд хөрвөх боломжтой, мөн үнэ цэний өөрчлөлтийн эрсдэл маш бага байна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр тайлагнадаг.

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дээр заасан бэлэн мөнгө болон богино хугацаат хадгаламжаас бүрдэнэ

### Түрээс

Компани нь аливаа гэрээ нь түрээс эсвэл түрээсийн зүйл агуулж байгаа эсэхийг гэрээ хийх бүрт үнэлж үздэг. Хэрвээ аливаа төлбөрөөр тогтсон хугацааны туршид тодорхой хөрөнгийг ашиглаж, хянах эрх гэрээнд үүссэн бол тухайн гэрээг түрээсийн гэрээ эсхүл уг гэрээнд түрээсийн зүйл агуулагдсан байна гэж үзнэ. Компанийн хувьд аливаа гүйлгээнд түрээслэгчийн оролцоогүй ба зөвхөн түрээслүүлэгчээр оролцсон.

#### *Компани түрээслүүлэгч үед*

Түрээсийн бүрэлдэхүүн хэсэг агуулсан гэрээг анх хэрэгжиж эхлэх эсвэл өөрчлөлт орсон үед Компани нь гэрээнд тусгасан үнийг түрээсийн бүрэлдэхүүн хэсэг бүрд тэдгээрийн тус бүрийн үнэнд суурилан хуваарилна. Компани нь түрээслүүлэгчийн хувьд, гэрээний эхэнд тухайн түрээсийг санхүүгийн эсвэл үйл ажиллагааны түрээсийн аль болохыг тодорхойлно.

Түрээсийн ангиллыг тодорхойлохдоо Компани нь тухайн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийн бараг бүгдийг нь шилжүүлсэн эсэхийг ерөнхий үнэлгээгээр шалгадаг. Хэрвээ шилжсэн бол тухайн түрээсийг санхүүгийн түрээс, шилжээгүй бол үйл ажиллагааны түрээс гэж ангилна. Энэхүү үнэлгээнд Компани нь хөрөнгийг эдийн засгийн ашиглах хугацааны ихээхэн хэсэгт түрээслүүлж буй эсэх зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан үздэг.

Хэрвээ гэрээ нь түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан байвал Компани нь гэрээний үнийг хуваарилахдаа СТОУС 15-г мөрддөг.

#### *Санхүүгийн түрээс*

Түрээс эхлэх өдөр Компани санхүүгийн түрээсийн хүрээнд эзэмшиж буй хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд түрээсийн цэвэр хөрөнгө оруулалттай тэнцэх дүнгээр авлага хэлбэрээр бүртгэнэ.

Компани түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтыг хэмжихдээ түрээсийн гэрээнд агуулагдсан дотоод хүүний хувийг ашигладаг. Компани нь түрээслүүлэгчийн цэвэр хөрөнгө оруулалтын өгөөжөөр хугацааны туршид тогтмол хувь хэмжээгээр хүүгийн орлого хүлээн зөвшөөрдөг ба тухайн жилийн ашиг, алдагдлын тайланд санхүүгийн орлогоор бүртгэдэг.

Компанийн зүгээс санхүүгийн түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтад дээр дурдсан ‘Санхүүгийн хэрэгслүүд’ хэсгийн бүртгэлээс хасалт болон үнэ цэний бууралтын шаардлагыг мөрдөнө. Мөн Компанийн зүгээс түрээсийн нийт хөрөнгө оруулалтыг тооцоолоход ашигладаг баталгаажаагүй үлдэгдэл үнийг тогтмол үнэлж хянан шинэчилдэг.

#### *Санхүүгийн түрээсийн өөрчлөлт*

Компанийн санхүүгийн түрээсийн өөрчлөлтийг дараах нөхцөлд тусдаа шинэ түрээс гэж бүртгэнэ:

- нэг эсвэл хэд хэдэн хөрөнгийн ашиглах эрхийг шинээр нэмснээр түрээсийн хамрах хүрээг өргөжүүлсэн; мөн
- гэрээний нөхцөлд нийцүүлэн тохируулсан, нэмэгдсэн хамрах хүрээтэй дүйцэхүйц хэмжээний төлбөрийн нэмэгдлийг тусгасан байдлаар төлбөрийн дүн нэмэгдсэн.

Тусдаа түрээсийн шалгуурыг хангаагүй санхүүгийн түрээсийн өөрчлөлтийн хувьд:

- Хэрэв өөрчлөгдсөн нөхцөл нь гэрээ байгуулагдсан өдөр хүчин төгөлдөр байсан бол тухайн түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилахуйц нөлөөлж байгаа бол, Компанийн зүгээс уг өөрчлөлтийг хэрэгжих өдрөөс эхлэн шинэ түрээс гэж бүртгэнэ. Энэ тохиолдолд суурь хөрөнгийг өөрчлөлт хийхийн өмнөхөн түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтын дансны дүнгээр хэмжинэ.

Дээрхээс бусад бүх тохиолдолд Компани санхүүгийн түрээсийн авлагад СТОУС 9-ийн өөрчлөлттэй холбоотой шаардлагыг хэрэглэнэ.

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)****Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үндсэн хөрөнгийг тухайн хөрөнгийн өртгөөс аливаа хуримтлагдсан элэгдэл болон аливаа үнэ цэний бууралтын гарзыг хассан дүнгээр нь бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийн өртөгт тухайн хөрөнгийг худалдан авах болон барьж байгуулахтай шууд холбогдон гарсан зардал, мөн удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангахтай холбоотой гарсан бусад зардлууд, мөн тухайн хөрөнгийг задлах, зайлуулах болон байрлаж байсан талбайг нь сэргээн засварлахад гарах зардлуудыг хамааруулна.

Хэрэв үндсэн хөрөнгийн тодорхой хэсгийн элэгдүүлэх хугацаа тухайн үндсэн хөрөнгөөс ялгаатай бол тэдгээрийг үндсэн хөрөнгийн тусдаа зүйл (гол бүрэлдэхүүн) гэж үзнэ.

Компани нь дараа үеийн зардлаас эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн зардлыг үнэн зөв хэмжих боломжтой болсон үед түүнийг үндсэн хөрөнгийн дансны үнэ дээр нэмэгдүүлэх буюу эсвэл тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцно:

<u>Үндсэн хөрөнгийн төрөл</u>	<u>Ашиглалтын хугацаа</u>
Барилга байгууламж	30
Тээврийн хэрэгсэл	10
Тавилга, эд хогшил	3-10
Компьютер	3

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашгийн хүлээлт үгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (борлуулснаас олсон орлого болон хөрөнгийн дансны үнийн зөрүүгээр тооцно)-ыг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

**Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэний бууралт**

Компанийн санхүүгийн бус хөрөнгүүдийн үнэ цэний бууралтын аливаа нэг шинж тэмдэг илэрсэн эсэхийг тайлант хугацааны эцэс бүрд үнэлж тодорхойлдог. Хэрэв ийм шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно. Нэгж хөрөнгө эсвэл мөнгөн орлого үүсгэгч нэгжийн (цаашид “МОҮН” гэх) дансны үнэ нь нөхөгдөх боломжит тооцоолсон үнээс их байвал үнэ цэний бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрдөг.

Хөрөнгийн эсвэл МОҮН-ийн нөхөгдөх үнэ гэдэг нь хөрөнгийн бодит үнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан цэвэр дүн болон хөрөнгийг ашигласнаар олж болох өгөөж хоёрын аль их дүнгээр нь тогтоогддог. Ашигласнаар олж болох өгөөжийг үнэлэхдээ татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтчилан тооцсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг ашигладаг. Хөрөнгийн үнэ цэний бууралтыг дангаар нь шалгах боломжгүй бол тэдгээрийг цаашид ашигласнаар бусад хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгөөс МОҮН хамааралгүйгээр дангаараа мөнгөн орлого бий болгох чадвартай хамгийн жижиг хөрөнгийн бүлэгт хамааруулан бүлгээр нь үнэ цэний бууралтыг үнэлнэ.

Нэгж хөрөнгө эсвэл түүний харьяалагдах МОҮН-ийн дансны үнэ нь нөхөгдөх боломжит тооцоолсон үнээс их байвал үнэ цэний бууралтын алдагдлыг бүртгэж, дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг.

Өмнөх тайлант жилүүдэд тодорхойлж бүртгэсэн үнэ цэний бууралтын алдагдлыг тайлант жилийн эцсээр эргэн шалгаж, уг алдагдал буурсан эсвэл алдагдалгүй болсон эсэхийг үнэлдэг. Нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлохдоо хэрэглэсэн тооцоолол өөрчлөгдсөн бол үнэ цэний бууралтын алдагдлыг буцаадаг. Ингэхдээ хөрөнгийн дансны үнэ тооцвол байх байсан хөрөнгийн дансны үнээс хэтрэхгүй байх хэмжээгээр элэгдэл хорогдлыг хассан цэвэр дүнгээр тооцоолж буцаадаг.

**Ажиллагсдын тэтгэмж***Богино хугацааны тэтгэмж*

Цалин ба түүнтэй холбогдох зардлуудыг Компанийн ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

### *Заавал төлөх даатгалын шимтгэлүүд*

Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь ашиг, алдагдлын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

### **Сангууд**

Компанид өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа, энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөцийг хүлээн зөвшөөрнө. Мөнгөний цаг хугацааны үнэ цэн материаллаг нөлөөтэй байх үед Компани нь тухайн өглөгтэй холбогдох хүүгийн түвшинг татварын өмнөх түвшинд тохируулж дискаунтлах замаар нөөцийн хэмжээг тодорхойлно. Аливаа нэг нөөцтэй холбоотой зардлыг ашиг, алдагдлаар аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь бусад үйл ажиллагааны зардалд толилуулна.

### **Татвар**

#### *Тайлант хугацааны орлогын албан татвар*

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар Компаний үйл ажиллагаагаа явуулж буй улсад хүчин төгөлдөр үйлчилж байсан.

#### *Хойшлогдсон татвар*

Хойшлогдсон орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог.

Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлогдсон орлогын албан татварын өр төлбөр нь гүүдвилээс эсвэл бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол
- Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүүний буцаалт нь ойрын ирээдүйд арилахгүй ба түр зөрүүг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлалгүй байгаа бол

Хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна.

Үл хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийг олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.

Арилжаалах зориулалттай хөрөнгийн бодит үнэ цэний дахин үнэлгээ, гадаад валютын ханшийн тэгшитгэл болон мөнгөн гүйлгээний хейджийн өөрчлөлттэй холбоотой бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдсан татвараас бусад хойшлогдсон татвар ба орлогын албан татвар нь орлогын тайланд орлогын албан татварын буцаан авалт эсвэл зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө. Үүний дараа нь бусад дэлгэрэнгүй орлогоос (БДО) орлогын тайлан руу холбогдох хойшлуулсан ашиг алдагдлын хамт дахин ангилагдана.

Мөн Компани нь өөрийн хөрөнгө гэж ангилсан санхүүгийн хэрэглүүртэй холбоотой зардал, төлбөрийн татварын үр дагаврыг өөрийн хөрөнгө гэж шууд хүлээн зөвшөөрнө. Компани нь хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй ба тооцоог цэвэр дүнгээр барагдуулах зорилготой бол цэвэршүүлэн тайлагнаж болно.

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (үргэлжлэл)

### Эздийн өмч

#### *Хувьцаат капитал*

Энгийн хувьцааг эздийн өмчид тусгана.

#### *Хуримтлагдсан ашиг*

Хуримтлагдсан ашиг нь ногдол ашиг зарласан дүнд хорогдуулсан, Компанийн өмнөх тайлант хугацаануудын хуримтлагдсан ашиг, алдагдлыг илэрхийлнэ. Мөн өмнөх үзийн залруулга, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөөний тохируулгуудыг багтааж болно.

### Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Холбоотой талууд гэдэгт Компанитай дараах байдлаар холбогдсон аж ахуйн нэгж болон хувь хүн орно. Үүнд:

(а) Компанитай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:

- (i) Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
- (ii) Компанид томоохон нөлөөлөлтэй эсвэл;
- (iii) Компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.

(б) Дараах нөхцөлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуйн нэгж нь Компанид хамааралтай болно. Үүнд:

- (i) Аж ахуйн нэгж болон Компани нь нэг ижил Группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой);
- (ii) Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани байх (эсвэл нөгөө аж ахуйн нэгж нь гишүүн болох Компанийн хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани);
- (iii) Аль аль аж ахуйн нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд байх;
- (iv) Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани байх;
- (v) Аж ахуйн нэгж нь Компанийн эсвэл Компанитай холбоотой аж ахуйн нэгжийн ажилчдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог байх. Хэрвээ Компани нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Компанитай холбоотой тал болно;
- (vi) Аж ахуйн нэгжид (а)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог байх;
- (vii) (а)(i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуйн нэгжид томоохон нөлөөтэй эсвэл уг аж ахуйн нэгжийн (эсвэл аж ахуйн нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг байх;
- (viii) Компани эсвэл Компанийн толгой компанид гол удирдах албан тушаалтай байх.

Холбоотой талуудын боломжит бүх хамаарлыг харгалзахдаа зөвхөн хуулийн хэлбэрийг биш хамаарлын мөн чанарыг чухалчлан анхаарсан болно. Холбоотой талуудтай хийсэн бүх материаллаг ажил гүйлгээ болон үлдэгдлийг санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудад тодруулсан бөгөөд дэлгэрэнгүйг тодруулга 17-с харна уу.

## 3. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон таамаглалууд

Үнэлэмж болон таамаглал, тооцооллыг өмнөх жилүүдийн туршлага ба холбогдох бусад хүчин зүйлсэд үндэслэн гүйцэтгэдэг. Үүнд бодит үр дүн нь зөрүүтэй байж болох тул таамаглал, тооцооллыг байнга хянадаг. Таамаглал тооцоололд гарсан өөрчлөлт нь зөвхөн тайлант жилд нөлөөлөх бол өөрчлөлтийг тухайн тайлант хугацаанд, хэрэв өөрчлөлтийн нөлөө тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд гарвал тухайн тайлант хугацаа болон өөрчлөлт гарах ирээдүйн тайлант жилүүдэд бүртгэлд тусгана.

Одоо байгаа нөхцөл байдал болон ирээдүйн өөрчлөлтийн талаарх таамаглал нь Компанийн хяналтаас гадуурх хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөж болох бөгөөд ийм өөрчлөлт гарсан үед тэдгээрийг таамаглалд тусгадаг. Санхүүгийн тайланд тусгагдсан их хэмжээний удирдлагын үнэлгээ/тооцооллын нөлөө хамгийн ихтэй зүйлсийн холбогдох үнэлгээ/тооцооллын талаар доор харуулав.

### Түрээсийн авлагад тооцсон үнэ цэний бууралтын сан

Бүх төрлийн санхүүгийн хөрөнгийн үнэ цэний бууралтын алдагдлыг хэмжихэд үнэлэмж шаардах ба тэр дундаа ирээдүйн мөнгөн урсгалын дүн болон хугацааны таамаг, барьцаа хөрөнгийн үнэлгээ, мөн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг үнэлэх зэрэг нь их хэмжээний үнэлэмж шаарддаг. Эдгээр тооцоолол нь олон хүчин зүйлээс хамаардаг бөгөөд тэдгээр хүчин зүйлсийн өөрчлөлт нь үнэ цэний бууралтын санд мөн нөлөөлдөг.

Компанийн ЗҮЦХА-ийн тооцоолол нь олон хувьсагч өгөгдөл болон тэдгээрийн харилцан хамаарлыг сонгохтой холбоотой дотоод таамаглалд тулгуурласан нарийн төвөгтэй загвараас гардаг. ЗҮЦХА-ын загвар дахь дараах бүрэлдэхүүнүүд нь нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж болон тооцоололд хамаарна:

## ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2025 оны 12 дугаар сарын 31

### 3. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон таамаглалууд (үргэлжлэл)

- Түрээслэгч бүрийн ЧМ-г тодорхойлоход ашигладаг Компанийн дотоод зээлийн чанарын үнэлгээний загвар. Үүнд мөн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг үнэлэх шалгуур багтана
- ЗҮЦХА-ын загварын боловсруулалт, буюу ашиглагдах томъёо болон өгөгдлүүдийн сонголт
- ДНБ, ажилгүйдлийн түвшин, инфляц зэрэг эдийн засгийн хувьсагчдын ЧМ-д үзүүлэх нөлөөг тодорхойлох
- Ирээдүйд чиглэсэн макроэдийн засгийн хувилбаруудыг сонгох, тэдгээрийн магадлалын жинг тогтоох, улмаар эдгээрийг ЗҮЦХА-ын загварт ашиглах эдийн засгийн өгөгдөл болгох

Компани бодит алдагдлын туршлага дээр үндэслэн ЗҮЦХА загваруудаа жил бүр дахин хянаж, шаардлагатай тохиолдолд тохируулга хийдэг бодлоготой.

### 4. Хүүгийн орлого

	2025	2024
	мян.төг	мян.төг
<i>Үр ашигт хүүний аргаар тооцсон хүүгийн орлого</i>		
Түрээсийн авлага	3,998,512	4,950,001
Хугацаатай хадгаламж	9,558,119	3,960,707
Дансны болон бусад авлага	900,894	1,086,569
Үнэт цаас	–	770,959
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	11,655	7,750
	<b>14,469,180</b>	<b>10,775,986</b>

### 5. Үйл ажиллагааны зардал

	2025	2024
	мян.төг	мян.төг
Цалингийн зардал	1,276,837	1,059,902
Нийгмийн даатгал шимтгэлийн зардал	159,931	133,662
Албан томилолтын зардал	68,419	81,628
Элэгдэл болон хорогдол	81,120	68,101
Богино хугацаат түрээсийн зардал	3,600	4,800
Бусад	304,483	376,615
	<b>1,894,390</b>	<b>1,724,708</b>

### 6. Бусад (зардал)/ орлого, цэвэр

	2025	2024
	мян.төг	мян.төг
Гадаад валютын хэрэгжсэн (гарз)/олз, цэвэр	(1,088)	965
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй (гарз)/олз, цэвэр	9,590	(54,491)
Данснаас хассанн түрээсийн авлагын алдагдал (Тод.12)	(4,924,284)	–
Бусад зардал	–	(587,204)
	<b>(4,915,782)</b>	<b>(640,730)</b>

### 7. Зээлийн үнэ цэний хүлээгдэж буй алдагдалын сан

	2025	2024
	мян.төг	мян.төг
<i>Тайлант жилд байгуулсан/(буцаасан)</i>		
Түрээсийн авлага (Тод.12)	274,292	3,855,088
Дансны болон бусад авлага (Тод.11)	(616,282)	–
	<b>(341,990)</b>	<b>3,855,088</b>

## ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

### Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2025 оны 12 дугаар сарын 31

#### 8. Орлогын албан татвар

##### 8.1 Орлогын албан татварын зардал

Орлогын албан татварын зардал нь дараахаас бүрдэнэ:

	2025 мян.төг	2024 мян.төг
Тайлант жилийн орлогын албан татвар	1,257,352	906,665
Хойшлогдсон татварын хөнгөлөлт	–	(3,942)
	<u>1,257,352</u>	<u>902,723</u>

Компани нь санхүүгийн тайлагналын зорилгоор орлогын татварын үндсэн дээр үнэлэгддэггүй эсвэл хасагддаг зүйлсийг зохицуулан орлогын татварын төлбөрийг тооцдог. Компани нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу 6 тэрбум (2024 онд: 6 тэрбум) төгрөг хүртэлх татвар ногдох орлогоос 10% (2024 онд: 10%), 6 тэрбум (2024 онд: 6 тэрбум)-аас илүү гарсан дүнгээс 25% (2024 онд: 25%) орлогын албан татвар төлдөг.

Компани нь татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг компанид хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд 2025 болон 2024 оны 12 дугаар сарын 31-нээр хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

	2025 мян.төг	2024 мян.төг
Татварын өмнөх ашиг	<u>8,000,998</u>	<u>4,555,460</u>
Хуульд заасан 25 хувиар тооцсон татварын зардал (2024: 10%)	2,000,250	455,546
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөө	1,516,509	502,720
Бага хувиар татвар ногдуулах орлогын нөлөө	(1,886,456)	473,942
Татвар ногдохгүй орлогын нөлөө	(372,951)	(529,485)
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	<u>1,257,352</u>	<u>902,723</u>

Компанийн 2025 онд ногдох үр ашигт татварын хувь хэмжээ нь 15.71% (2024: 19.82%) байна.

##### 8.2 Орлогын албан татварын өр төлбөр

	2025 мян.төг	2024 мян.төг
1-р сарын 1-нээрх	797,743	1,015,152
Тайлант үеийн орлогын албан татварын зардал	1,257,352	906,665
Бусдад суутгуулсан татвар	(1,838,387)	(1,124,074)
<b>12-р сарын 31-нээрх</b>	<u><b>216,708</b></u>	<u><b>797,743</b></u>

#### 9. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

	2025 мян.төг	2024 мян.төг
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</i>		
Бэлэн мөнгө	674	769
Харилцах данс	687,182	1,847,294
Хугацаатай хадгаламж (3 сараас доош хугацаатай)	84,612,822	–
	<u>85,300,678</u>	<u>1,848,063</u>

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь богино хугацаатай, хөрвөх чадвар сайтай хөрөнгүүд бөгөөд бэлэн мөнгө рүү түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай байдаг. Банканд байршуулсан хөрөнгийн дансны үнэ нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байх ба аливаа барьцаагүй болно. Банканд дахь хадгаламж нь арилжааны банканд байршуулсан 3 сарын хугацаатай хадгаламжуудаас бүрдэх ба хүүгийн хувь хэмжээ нь 13.3% байна. Moody's-ийн үнэлгээгээр эдгээр харилцагч банкуудын зээлжих чадварыг В1 (2024: В2) гэж тодорхойлогдсон. Удирдлага холбогдох болзошгүй эрсдэлийн алдагдал нь маш бага гэж үзсэн.

## ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

### Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2025 оны 12 дугаар сарын 31

#### 10. Хугацаатай хадгаламж

	2025 мян.төг	2024 мян.төг
<i>Хугацаатай хадгаламж (3 сараас дээш хугацаатай):</i>		
Голомт Банк	–	40,000,000
Төрийн Банк	–	23,000,000
Хуримтлагдсан хүүгийн авлага	–	1,044,131
	<u>–</u>	<u>64,044,131</u>

Банкан дахь хадгаламж нь арилжааны банканд байршуулсан 6 сарын хугацаатай хадгаламжуудаас бүрдэх ба хүүгийн хувь хэмжээ нь 13.3%-аас 14.3% хооронд байна. Moody's-ийн үнэлгээгээр зээлжих чадварыг 2024 оны 12-р сарын 31-ээр B2 гэж тодорхойлогдсон. Удирдлага холбогдох болзошгүй эрсдэлийн алдагдал нь маш бага гэж үзсэн.

#### 11. Дансны болон бусад авлага

	2025 мян.төг	2024 мян.төг
Дансны авлага	23,264,805	29,500,641
Бусад авлага	9,352,574	9,352,574
Бусад	5,475	114
	<u>32,622,854</u>	<u>38,853,329</u>
Үнэ цэний бууралтын алдагдлын сан	(9,455,391)	(10,071,673)
	<u>23,167,463</u>	<u>28,781,656</u>

Дансны авлагад Хөдөө Аж Ахуйн Корпораци ТӨХХК-с авах авлага багтах бөгөөд Компанийн Хувьцаа эзэмшигчийн 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 09 дүгээр шийдвэрээр холбогдох санхүүгийн түрээсийн авлагыг дансны авлага руу ангилж бүртгэсэн.

Хүснэгтэд дансны хөдөлгөөнийг холбогдох үнэ цэний бууралтын сангийн хөдөлгөөнтэй харуулав:

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
<b>Дансны болон бусад авлага</b>				
<b>Нийт дансны дүн</b>				
2025 оны 1 сарын 1-нээр	12,751	29,489,403	9,351,175	38,853,329
Шинээр олгосон эсвэл худалдаж авсан	2,852,023	–	–	2,852,023
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(2,833,608)	(6,381,916)	–	(9,215,524)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	–	133,026	–	133,026
2025 оны 12 сарын 31-нээр	<u>31,166</u>	<u>23,240,513</u>	<u>9,351,175</u>	<u>32,622,854</u>
<b>Эрсдэлийн сан</b>				
2025 оны 1 сарын 1-нээр	–	720,498	9,351,175	10,071,673
Тайлант жилд байгуулсан/буцаасан (Тод.7)	–	(616,282)	–	(616,282)
2025 оны 12 сарын 31-нээр	<u>–</u>	<u>104,216</u>	<u>9,351,175</u>	<u>9,455,391</u>
<b>Дансны болон бусад авлага</b>				
<b>Нийт дансны дүн</b>				
2024 оны 1 сарын 1-нээр	12	31,853,034	9,351,175	41,204,221
Шинээр олгосон эсвэл худалдаж авсан	77,082	–	–	77,082
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(64,343)	(3,450,200)	–	(3,514,543)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	–	1,086,569	–	1,086,569
2024 оны 12 сарын 31-нээр	<u>12,751</u>	<u>29,489,403</u>	<u>9,351,175</u>	<u>38,853,329</u>
<b>Эрсдэлийн сан</b>				
2024 оны 1 сарын 1 болон 12 сарын 31-нээр	<u>–</u>	<u>720,498</u>	<u>9,351,175</u>	<u>10,071,673</u>

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**

**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2025 оны 12 дугаар сарын 31**

**12. Түрээсийн авлага**

	<b>2025</b>	<b>2024</b>
	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>
Түрээсийн авлага	30,479,731	37,250,120
Хуримтлагдсан хүү болон торгуулийн хүүгийн авлага	10,516,097	12,901,069
	<b>40,995,828</b>	<b>50,151,189</b>
Үнэ цэний бууралтын алдагдлын сан	(20,792,432)	(22,425,781)
	<b>20,203,396</b>	<b>27,725,408</b>

Тайлангийн өдрөөрх түрээсээрх нийт хөрөнгө оруулалтын дүн ба түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтын уялдааг Тодруулга 18.(3)-с харна уу.

2025 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх түрээсийн дансны үлдэгдлийг салбар болон шатлалаар харуулбал:

	<b>Шатлал 1</b>	<b>Шатлал 2</b>	<b>Шатлал 3</b>	<b>Нийт</b>
	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>
<b>2025 оны 12 сарын 31-нээр</b>				
Тээвэр ба логистик	1,471,716	359,725	–	1,831,441
Уул уурхай ба олборлолт	–	–	5,801,712	5,801,712
Үйлдвэрлэл	–	–	10,866,510	10,866,510
Эрчим хүч	16,277,226	–	6,218,939	22,496,165
<b>Түрээсийн авлагын дансны нийт дүн</b>	<b>17,748,942</b>	<b>359,725</b>	<b>22,887,161</b>	<b>40,995,828</b>
Үнэ цэний бууралтын алдагдлын сан	–	(29,587)	(20,762,845)	(20,792,432)
<b>Цэвэр түрээсийн авлагын нийт дүн</b>	<b>17,748,942</b>	<b>330,138</b>	<b>2,124,316</b>	<b>20,203,396</b>
<b>2024 оны 12 сарын 31-нээр</b>				
Тээвэр ба логистик	2,172,199	658,333	–	2,830,532
Уул уурхай ба олборлолт	–	–	13,337,490	13,337,490
Үйлдвэрлэл	–	–	10,229,504	10,229,504
Эрчим хүч	18,107,210	–	5,646,453	23,753,663
<b>Түрээсийн авлагын дансны нийт дүн</b>	<b>20,279,409</b>	<b>658,333</b>	<b>29,213,447</b>	<b>50,151,189</b>
Үнэ цэний бууралтын алдагдлын сан	–	(219,888)	(22,205,893)	(22,425,781)
<b>Цэвэр түрээсийн авлагын нийт дүн</b>	<b>20,279,409</b>	<b>438,445</b>	<b>7,007,554</b>	<b>27,725,408</b>

Түрээсийн авлагын чанарын шинжилгээ дараах байдалтай байна:

	<b>2025</b>	<b>2024</b>
	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>
<i>Шатлал 1</i>		
Хугацаа хэтрээгүй үнэ цэнэ буураагүй	17,748,942	20,279,409
	<b>17,748,942</b>	<b>20,279,409</b>
<i>Шатлал 2</i>		
30-с бага хоног хугацаа хэтэрсэн	–	216,023
360 хоногоос дээш хугацаа хэтэрсэн	359,725	442,310
	<b>359,725</b>	<b>658,333</b>
<i>Шатлал 3</i>		
360 хоногоос дээш хугацаа хэтэрсэн	22,887,161	29,213,447
	<b>22,887,161</b>	<b>29,213,447</b>
Хасах: Үнэ цэний бууралтын алдагдлын сан	(20,792,432)	(22,425,781)
<b>Нийт цэвэр түрээсийн авлага</b>	<b>20,203,396</b>	<b>27,725,408</b>

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2025 оны 12 дугаар сарын 31

12. Түрээсийн авлага (үргэлжлэл)

Хүснэгтэд дансны хөдөлгөөнийг холбогдох үнэ цэний бууралтын сангийн хөдөлгөөнтэй харуулав:

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
<b>Нийт дансны дүн</b>				
2025 оны 1 сарын 1-нээр	20,279,409	658,333	29,213,447	50,151,189
Шинээр олгосон эсвэл худалдаж авсан	3,239,508	–	–	3,239,508
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(6,071,576)	(130,256)	(871,148)	(7,072,980)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	133,410	(161)	1,376,787	1,510,036
Данснаас хассан (Тод.6)	–	–	(6,831,925)	(6,831,925)
Шатлал 2-с 1-т шилжсэн	168,191	(168,191)	–	–
<b>2025 оны 12 сарын 31-нээр</b>	<b>17,748,942</b>	<b>359,725</b>	<b>22,887,161</b>	<b>40,995,828</b>
<b>Эрсдэлийн сан</b>				
2025 оны 1 сарын 1-нээр	–	219,888	22,205,893	22,425,781
Тайлант жилд байгуулсан/(буцаасан) (Тод.7)	–	(190,301)	464,593	274,292
Данснаас хассан (Тод.6)	–	–	(1,907,641)	(1,907,641)
<b>2025 оны 12 сарын 31-нээр</b>	<b>–</b>	<b>29,587</b>	<b>20,762,845</b>	<b>20,792,432</b>
<b>Нийт дансны дүн</b>				
2024 оны 1 сарын 1-нээр	32,517,492	1,472,058	28,423,560	62,413,110
Шинээр олгосон эсвэл худалдаж авсан	3,284,488	–	–	3,284,488
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(15,432,784)	(318,234)	(516,108)	(16,267,126)
Хуримтлагдсан хүүгийн цэвэр хөдөлгөөн	(258,354)	(326,924)	1,305,995	720,717
Шатлал 2-с 1-т шилжсэн	168,567	(168,567)	–	–
<b>2024 оны 12 сарын 31-нээр</b>	<b>20,279,409</b>	<b>658,333</b>	<b>29,213,447</b>	<b>50,151,189</b>
<b>Эрсдэлийн сан</b>				
2024 оны 1 сарын 1-нээр	5	67,593	18,503,095	18,570,693
Тайлант жилд байгуулсан (Тод.7)	(5)	152,295	3,702,798	3,855,088
<b>2024 оны 12 сарын 31-нээр</b>	<b>–</b>	<b>219,888</b>	<b>22,205,893</b>	<b>22,425,781</b>

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК**

**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2025 оны 12 дугаар сарын 31**

**13. Үндсэн хөрөнгө**

	Барилга	Тээврийн хэрэгсэл	Компьютер	Тавилга эд хогшил	Нийт
<b>2025 оны 12 сарын 31-нээр</b>					
<b>Өртгөөр</b>					
2025 оны 1-р сарын 1	1,208,000	183,907	178,158	84,892	1,654,957
Нэмэгдсэн	–	–	29,910	–	29,910
2025 оны 12-р сарын 31	<u>1,208,000</u>	<u>183,907</u>	<u>208,068</u>	<u>84,892</u>	<u>1,684,867</u>
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>					
2025 оны 1-р сарын 1	41,039	128,806	131,763	58,538	360,146
Тайлант жилд байгуулсан (Тод.5)	40,267	15,701	16,261	7,971	80,200
2025 оны 12-р сарын 31	<u>81,306</u>	<u>144,507</u>	<u>148,024</u>	<u>66,509</u>	<u>440,346</u>
<b>Дансны цэвэр дүн</b>	<b><u>1,126,694</u></b>	<b><u>39,400</u></b>	<b><u>60,044</u></b>	<b><u>18,383</u></b>	<b><u>1,244,521</u></b>
<b>2024 оны 12 сарын 31-нээр</b>					
<b>Өртгөөр</b>					
2024 оны 1-р сарын 1	1,208,000	183,907	129,376	84,892	1,606,175
Нэмэгдсэн	–	–	48,782	–	48,782
2024 оны 12-р сарын 31	<u>1,208,000</u>	<u>183,907</u>	<u>178,158</u>	<u>84,892</u>	<u>1,654,957</u>
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>					
2024 оны 1-р сарын 1	662	113,063	128,697	50,544	292,966
Тайлант жилд байгуулсан (Тод.5)	40,377	15,743	3,066	7,994	67,180
2024 оны 12-р сарын 31	<u>41,039</u>	<u>128,806</u>	<u>131,763</u>	<u>58,538</u>	<u>360,146</u>
<b>Дансны цэвэр дүн</b>	<b><u>1,166,961</u></b>	<b><u>55,101</u></b>	<b><u>46,395</u></b>	<b><u>26,354</u></b>	<b><u>1,294,811</u></b>

**14. Дансны болон бусад өглөг**

	2025 мян.төг	2024 мян.төг
Дансны өглөг	154,692	155,185
Суутган татварын өглөг	28,380	30,741
Буцаан олголтын тооцоо	4,871	4,912
Орлогын албан татвараас бусад татварын өглөгүүд	61,283	–
	<b><u>249,226</u></b>	<b><u>190,838</u></b>

**15. Хувьцаат капитал**

Компанийн дүрмийн сан нь 2025 болон 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ. Гаргасан бүх хувьцаа бүрэн төлөгдсөн.

Компанийн хувьцаа эзэмшигч нь 2025 болон 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

	2025	2024
Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК	100.00%	100.00%

## **16. Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага**

2025 болон 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар Компанид аливаа болзошгүй өр төлбөр, үүрэг хариуцлага байхгүй болно.

### **Баталгаа**

Баталгаа нь гуравдагч этгээд төлбөрийн үүрэг даалгавраа биелүүлж чадахгүй тохиолдолд тухайн этгээдийн өмнөөс төлбөр хийх үүрэг хүлээхийг хэлнэ. Компанид 2025 болон 2024 оны эцсийн байдлаар гаргасан баталгаа байхгүй.

### **Шүүхийн нэхэмжлэл**

Компани нь шүүхийн нэхэмжлэлтэй хэрхэн ажиллах талаар тогтсон дотоод журамтай. Нэгэнт мэргэжлийн зөвлөгөө авсан, гарч болох хохирлын хэмжээг зохистойгоор тооцоолсон бол тухайн нэхэмжлэл Компанийн санхүүгийн байдалд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс хамгаалан дансандаа залруулах бичилт хийдэг.

2025 болон 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар Компанийн нэр дээр томоохон шүүхийн нэхэмжлэл үүсээгүй байна.

### **Татварын хууль тогтоомж**

Монгол Улсын татварын хууль тогтоомж нь тогтмол шинэчлэгдэн өөрчлөгдөж, эрх бүхий байгууллагуудын тодорхойлолт нь цаг хугацааны явцад хэлбэлзэх хандлагатай байдаг. Иймд эдгээр хууль тогтоомжийг компанийн гүйлгээ болон үйл ажиллагаанд хэрэглэн тайлбарласан удирдлагын тодорхойлолтыг холбогдох эрх бүхий байгууллагууд маргаан үүсгэн шалгах, дахин үнэлэх, өөрөөр тайлбарлах боломжтой.

Монгол Улсын татварын байгууллагууд холбогдох хууль тогтоомж болон татварын үнэлгээг тайлбарлахдаа харьцангуй хатуу байр суурь баримтлах хандлагатай байдаг бөгөөд өмнө нь маргаан үүсгэн шалгаагүй гүйлгээ, үйл ажиллагааг ч дахин шалгаж, маргаан үүсгэх боломжтой байдаг. Үүний үр дүнд Компанид томоохон хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алданги ногдуулах эрсдэл үүсэж болзошгүй юм. Татварын байгууллага нь шалгалт явуулж буй жилийн өмнөх тав хүртэлх календарь жилийн татварын тайлан, баримт бичгийг хянан шалгах эрхтэй бөгөөд тодорхой нөхцөлд энэхүү шалгалтын хүрээ сунгагдаж болзошгүйг анхаарах нь зүйтэй.

Монгол Улсын татварын хууль тогтоомж нь нэмэгдсэн өртгийн албан татвар, суутган төлөгчийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар гэх мэт чиглэлүүдэд хангалттай тодорхой зааварчилгаа, зөвлөгөө өгдөггүй. Иймд Компанийн зүгээс зарим тохиолдолд эдгээр хууль тогтоомжийг компанийн нийт татварыг бууруулахуйц байдлаар ашиглах тохиолдол байдаг. Тиймээс захиргааны байгууллагууд болон шүүхэд сүүлийн жилүүдэд гарч буй өөрчлөлт, чиг хандлагаас үүдэн Компанийн дээр дурдсан татварын төрлүүд илүү нарийвчилсан хяналт, шалгалтад өртөх магадлал нэмэгдэж байна. Татварын байгууллагаас маргаан үүсгэн шалгасан тохиолдолд үүсэж болох үр дагаврыг үнэн зөвөөр урьдчилан тооцоолох боломжгүй боловч, ийм үр дагавар нь Компанийн санхүүгийн байдал болон нийт үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжтой.

Удирдлагын зүгээс татварын эрсдэлийг тогтмол үнэлдэг ба хангалттай нарийвчлалтай урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал өөрчлөлтөс үүдээд уг үнэлгээ цаашид өөрчлөгдөх боломжтой юм.

## **17. Холбоотой талуудын тодруулга**

Компанийн холбоотой талуудыг доор харуулав:

- Монгол улсын засгийн газар – Дээд шатны хяналт тавих байгууллага
- Сангийн яам – Дунд шатны хяналт тавих байгууллага
- Монгол Улсын Хөгжлийн Банк – Толгой компани
- Ди Би Эм Ассет Менежмент ХХК – Зэргэлдээ компани
- Төрийн банк ХК – Нэгдсэн хяналт буюу Монгол Улсын Засгийн Газрын хяналтад байдаг дотоодын арилжааны банк
- Бусад төрийн өмчит аж ахуйн нэгжүүд – Нэгдсэн хяналт буюу Монгол Улсын Засгийн Газрын хяналтад байдаг дотоодын аж ахуйн нэгжүүд

**17. Холбоотой талуудын тодруулга (үргэлжлэл)**

2024 болон 2025 оны 12-р сарын 31-ний байдлаар холбоотой талуудын хөрөнгө болон өр төлбөрийн үлдэгдэл, мөн тэдгээртэй хийсэн ажил гүйлгээг доор толилуулав. Үүнд:

	<b>2025</b>	<b>2024</b>
	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>
<b>Холбоотой талуудын дансны үлдэгдэл</b>		
<i><b>Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК:</b></i>		
Харилцах данс	142,971	8,293
Дансны болон бусад авлага	1,399	1,399
<i><b>Төрийн Банк ХК:</b></i>		
Харилцах данс	520,537	1,740,956
Хугацаатай хадгаламж (3 сараас доош хугацаатай)	54,000,000	23,000,000
Хугацаатай хадгаламжийн хуримтлагдсан хүүгийн авлага	524,712	224,460
<i><b>Бусад төрийн өмчит аж ахуйн нэгжүүд:</b></i>		
Дансны болон бусад авлага	23,251,203	29,500,092
Дансны авлагын үнэ цэний бууралтын алдагдлын сан	(104,214)	(720,498)
Түрээсийн авлага	16,735,562	19,278,233
Хуримтлагдсан хүү болон торгуулийн хүүгийн авлага	173,454	39,715
Дансны болон бусад өглөг	484	40,616
<i><b>Удирдлагын гол ажилтнууд</b></i>		
Дансны болон бусад өглөг	–	13
<b>Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ</b>		
<i><b>Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК:</b></i>		
Банкны шимтгэл	2	–
<i><b>Төрийн Банк ХК:</b></i>		
Харилцах дансны хүүгийн орлого	11,493	7,070
Хугацаатай хадгаламжийн хүүгийн орлого	2,910,124	819,076
Авсан бараа болон үйлчилгээ	292,299	(150)
<i><b>Бусад төрийн өмчит аж ахуйн нэгжүүд:</b></i>		
Түрээсийн хүүгийн орлого	2,541,074	3,273,248
Үнэт цаасны хүүгийн орлого	–	770,959
Дансны авлагын торгуулийн хүүгийн орлого	900,894	1,086,569
Авсан бараа болон үйлчилгээ	–	(100,571)

**Холбоотой талуудтай хийсэн гүйлгээний нөхцөлүүд**

Бизнесийн ердийн үйл ажиллагааны үр дүнд дээр дурдсан ажил гүйлгээ, үлдэгдлүүд үүссэн болно. Холбоотой талуудын төлсөн болон хүлээн авсан хүү нь ердийн арилжааны хүүгээр тооцогдсон. Холбоотой талуудад олгосон зээл ба урьдчилгаанаас бусад үлдэгдэл дүн барьцаагүй болно. Түүнчлэн холбоотой талуудтай холбоотой авлага, өглөгт ямар нэгэн баталгаа өгсөн болон авсан тохиолдол байхгүй.

**17. Холбоотой талуудын тодруулга (үргэлжлэл)***Гол удирдах албан тушаалтнуудын цалин, урамшуулал*

Төлөөлөн удирдах зөвлөл болон удирдлагад олгосон цалин, урамшууллын нэгтгэлийг доор толилуулав:

	<b>2025</b>	<b>2024</b>
	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>
<b>Гүйцэтгэх захирал болон нэгжийн захирлууд</b>		
Цалин	436,165	318,216
Нийгмийн даатгалын шимтгэл	50,174	48,800
	<b>486,339</b>	<b>367,016</b>
<b>Төлөөлөн удирдах зөвлөл</b>		
Цалин	51,128	30,176
Нийгмийн даатгалын шимтгэл	6,135	4,536
	<b>57,263</b>	<b>34,712</b>

**18. Эрсдэлийн удирдлага**

Компани санхүүгийн хэрэглүүрийг ашигласнаас үүдэн дараах төрлийн эрсдэлүүдэд өртөж байдаг:

- Зээлийн эрсдэл
- Зах зээлийн эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл

Энэхүү тодруулга нь дээрх эрсдэл тус бүрийн Компанид нөлөөлөх нөлөөлөл, уг эрсдэлийг тооцоолох, удирдах Компанийн зорилго, бодлого, авах арга хэмжээ, мөн Компанийн капиталын удирдлагын талаарх мэдээллийг агуулсан.

Хувьцаа эзэмшигч нь Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, түүнийг хянах ерөнхий үүрэг хариуцлагыг хүлээж байдаг..

**(1) Зээлийн эрсдэл**

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Компанид тулгарч буй эрсдэлүүдийг тодорхойлох, шинжлэх, тохиромжтой эрсдэлийн хязгаар, хяналтыг бий болгох, эрсдэлийг хянах, хязгаарыг мөрдөхөд чиглэгдсэн байдаг. Эрсдэлийн удирдлагын бодлого болон системийг зах зээлийн нөхцөл байдал болон Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа өөрчлөлтүүдийг тусгахын тулд тогтмол хянаж байдаг.

Компани нь ажилчдад тэдний үүрэг болон хариуцлагыг ухамсарлуулж чадахуйц дэг журамтай, үр дүнтэй хяналтын орчныг өөрийн сургалт болон удирдлагын стандарт, горимуудыг хэрэгжүүлэх замаар бий болгохыг зорьж ажилладаг.

Зээлийн эрсдэл гэдэг нь гэрээ байгуулагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс Компанид санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл бөгөөд энэ нь голдуу үйлчлүүлэгчдээс авах Компанийн авлагаас үүдэлтэй байдаг.

Компанийн зээлийн эрсдэл нь юун түрүүнд банкин дах бэлэн мөнгө, дансны болон бусад авлагатай холбоотой байдаг. Удирдлага нь эдгээр зээлийн эрсдэлд тогтмол хяналт тавьдаг.

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь зээлийн хамгийн их эрсдэлийг илэрхийлж байдаг. 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн хөрөнгийн хамгийн их хүлээх зээлийн эрсдэл дараах байдалтай байна:

	<b>2025</b>	<b>2024</b>
	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	85,300,004	1,847,294
Хугацаатай хадгаламж	–	64,044,131
Дансны болон бусад авлага	23,167,463	28,781,656
Түрээсийн авлага	20,203,396	27,725,408
	<b>128,670,863</b>	<b>122,398,489</b>

*Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө болон хугацаатай хадгаламж*

Компанийн төлөгдөх байдлын эрсдэлд өртөх байдал нь гол төлөв Компанийн хадгаламж байршуулсан банкнуудын онцлог шинж чанараас хамаардаг. Компанийн удирдлага нь зээлийн бодлогыг бий болгосон бөгөөд үүний дагуу банк тус бүрийг зээлийн чадварт нь тус тусад нь дүн шинжилгээ хийдэг.

**18. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)****(1) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

Компанийн үнэлгээнд гаднын үнэлгээ, хэрэв боломжтой бол санхүүгийн тайлангууд, зээлийн зэрэглэл тогтоох байгууллагын мэдээлэл, салбарын мэдээлэл болон зарим тохиолдолд Монголбанкны лавлагаа орно.

Компани нь Монгол Улсын эдийн засгийн орчин, банкны салбарыг ажиглаж, эдийн засгийн нөхцөл байдалд аливаа хүндрэл үүсэх тохиолдолд үүсэж болох эрсдэлийг хязгаарлах бодлого баримталдаг.

*Дансны ба бусад авлага ба Түрээсийн авлага*

Компанийн түрээсийн авлагын эрсдэл нь голдуу худалдан авагч тус бүрийн хувийн онцлогоос хамааралтай байдаг. Удирдлага нь түрээсийн авлагын эрсдэлд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс болох харилцагчдын үйл ажиллагаагаа явуулж буй улс орон болон тухайн салбарын төлбөр гүйцэтгэх чадваргүй болох эрсдэл зэрэг Компанийн харилцагчдын онцлогийг харгалзан үздэг.

Компанийн стандарт нөхцөлийг харилцагчдад санал болгохоос өмнө удирдлага нь шинэ харилцагч тус бүрийн эргэн төлөх чадварыг тусгайлан шинжилж, эрсдэлийн бодлогоо боловсруулдаг.

Компанийн хяналт нь гадаад үнэлгээг авч үздэг, үүнд боломжтой бол санхүүгийн тайлан, зээлийн зэрэглэл тогтоох байгууллагын мэдээлэл, бизнесийн салбарын мэдээлэл болон зарим тохиолдолд банкны лавлагаа, тодорхойлолт багтдаг.

Харилцагч тус бүрээр төлбөр төлөх дэлгэрэнгүй хуваарь гаргах байдлаар түрээсийн авлагаас хүлээх эрсдэлийг хязгаарладаг. Компани харилцагчийн эрсдэлийг тус бүрд нь хянадаг. Компанийн стандарт, бодлого журамд зааснаар санхүүгийн түрээсийн гэрээний төлбөр бүрэн төлөгдөж дуусах хүртэлх хугацаанд түрээслэгчийн санхүүгийн хөрөнгийг эзэмших эрхтэй байх ёстой. Компани нь түрээслэгчийн эрсдэл болон санхүүгийн түрээсийн эх үүсвэрээс хамаараад урьдчилгаа төлбөрийг 15% байршуулахыг шаарддаг.

Компани нь мөн түрээсийн авлагын эрсдэлийн төвлөрлийг салбараар нь хянадаг ба эдгээр нь ихэвчлэн үйлдвэрлэл, уул уурхай, эрчим хүч ба тээвэр логистикийн салбарууд байна.

Дараах хүснэгтээр Компанийн түрээсийн авлагын нийт дүнг салбараар нь харуулав:

	<b>2025</b>	<b>2024</b>
	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>
Улсын салбар	16,909,016	19,317,948
Хувийн салбар	24,086,812	30,833,241
	<b>40,995,828</b>	<b>50,151,189</b>
Үнэ цэний бууралтын алдагдлын сан	(20,792,432)	(22,425,781)
	<b>20,203,396</b>	<b>27,725,408</b>

Зээлийн эрсдэлд өртөлт болон барьцаа хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах байдлаар харуулав:

	<b>2025 оны 12-р сарын 31</b>		<b>2024 оны 12-р сарын 31</b>	
	<b>Нийт эрсдэл</b>	<b>Барьцаа хөрөнгө</b>	<b>Нийт эрсдэл</b>	<b>Барьцаа хөрөнгө</b>
	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>
Түрээсийн авлага	20,203,396	64,404,419	27,725,408	86,314,610

**18. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)****(2) Зах зээлийн эрсдэл**

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт тухайлбал хүүгийн хувь, санхүүгийн түрээс болон гадаад валютын ханш өөрчлөгдсөнөөр Компанийн орлогод сөргөөр нөлөөлөх эрсдэл юм. Зах зээлийн эрсдэлийн удирдлагын гол зорилго нь хүлээн зөвшөөрөгдөх параметруудийн хүрээнд эрсдэлийг хянах, удирдсанаар эрсдэлийн өгөөжийг хамгийн оновчтой байлгах явдал юм.

*(i) Ханишийн эрсдэл*

Компанид бүртгэлийн валют болох төгрөгөөс өөр гадаад валютаарх түрээсийн авлага болон мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө дээр валютын эрсдэл үүсдэг. Эдгээр ажил гүйлгээнүүд хийгддэг валютууд нь Ам.Доллар, Евро, Япон Иен болон Хятад Юань байна. Компани нь гадаад валютын хэлбэлзлийг тогтмол хянадаг ба валютын эрсдэлийг бууруулах зорилгоор ирээдүйд хийгдэх гадаад валютаарх мөнгөн урсгалыг хянадаг.

*(ii) Хүүгийн түвшний эрсдэл*

Хүүгийн түвшний эрсдэл нь ирээдүйд хүүгийн түвшний хэлбэлзэл тэр дундаа хөвөгч хүүтэй хадгаламж болон түрээсийн авлагаас үүсэх эрсдэл юм. Хүүгийн түвшний эрсдэлийн удирдлагын гол зорилго нь санхүүгийн зардал болон хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотой тодорхойгүй байдлыг багасгах явдал юм.

Компанийн хүүгийн түвшний өөрчлөлтөөс хамааралтай зах зээлийн эрсдэл нь Компанийн зээлтэй үндсэндээ холбоотой байна.

Эрсдэлийг бууруулах Компанийн бодлого нь тогтмол хүүгийн түвшинтэй зээл авах юм. Тайлангийн өдрөөрх Компанийн хүүтэй санхүүгийн хэрэгслүүдийн багц дараах байдалтай байна:

	<b>2025</b>	<b>2024</b>
	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>
<b>Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэгслүүд</b>		
<b>Санхүүгийн хөрөнгө</b>		
Хугацаатай хадгаламж	–	64,044,131
Санхүүгийн түрээсийн авлага	20,203,396	27,725,408
	<b>20,203,396</b>	<b>91,769,539</b>

## 18. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

## (3) Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Компани өөрийн санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болох эрсдэл юм. Компани нь хэвийн болон онцгой нөхцөлд их хэмжээний алдагдалд орохгүйгээр, Компанийн нэр хүндэд хохирол учруулах эрсдэлийг бий болгохгүйгээр өр төлбөрөө гэрээний хугацаанд төлж барагдуулахад хүрэлцэхүйц хөрвөх чадварыг байнга барьж байх ёстой гэдэг зарчмаар хөрвөх чадварыг удирдан зохицуулдаг.

Компанийн хувьцаа эзэмшигч нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хариуцдаг ба Компанийн богино, дунд ба урт хугацааны санхүүжилт болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын шаардлагад нийцсэн хөрвөх чадварын бүтцийг бий болгох үүрэгтэй. Компани санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн төлөгдөх хугацаа, банкнаас зээл авах чадавх, зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, мөнгөн урсгалын таамаглал болон гүйцэтгэлд үндэслэн хөрвөх чадварын эрсдэлийг удирддаг.

Дараах хүснэгтэд Компанийн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг гэрээгээр хүлээсэн үүргийн эргэн төлөлтийн дискаунтчлаагүй дүнд суурилан дуусах хугацаагаар нь ангилан харууллаа:

	3 сараас доош мян.төг	3-аас 6 сар мян.төг	6 сараас 1 жил мян.төг	1-ээс 5 жил мян.төг	5 жилээс дээш мян.төг	Нийт мян.төг
<b>2025 оны 12 сарын 31</b>						
<b>Санхүүгийн хөрөнгө</b>						
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	87,458,767	–	–	–	–	87,458,767
Хугацаатай хадгаламж	–	–	–	–	–	–
Дансны болон бусад авлага*	23,194,459	–	–	–	–	23,194,459
Түрээсийн авлага**	24,604,062	2,533,187	3,360,252	13,699,006	–	44,196,507
	<b>135,257,288</b>	<b>2,533,187</b>	<b>3,360,252</b>	<b>13,699,006</b>	–	<b>154,849,733</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>						
Дансны болон бусад өглөг	159,563	–	–	–	–	159,563
<b>Цэвэр дүн</b>	<b>135,416,851</b>	<b>2,533,187</b>	<b>3,360,252</b>	<b>13,699,006</b>	–	<b>155,009,296</b>
<b>2024 оны 12 сарын 31</b>						
<b>Санхүүгийн хөрөнгө</b>						
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,848,063	–	–	–	–	1,848,063
Хугацаатай хадгаламж	26,044,131	38,000,000	–	–	–	64,044,131
Дансны болон бусад авлага*	38,853,329	–	–	–	–	38,853,329
Түрээсийн авлага**	43,149,250	2,785,288	3,901,337	20,352,797	101,411	70,290,083
	<b>109,894,773</b>	<b>40,785,288</b>	<b>3,901,337</b>	<b>20,352,797</b>	<b>101,411</b>	<b>175,035,606</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>						
Дансны болон бусад өглөг	190,838	–	–	–	–	190,838
<b>Цэвэр дүн</b>	<b>109,703,935</b>	<b>40,785,288</b>	<b>3,901,337</b>	<b>20,352,797</b>	<b>101,411</b>	<b>174,844,768</b>

\* Дансны болон бусад авлага нь нийт дүнгээр илэрхийлэгдсэн.

\*\* Түрээсийн авлага нь нийт дүнгээр илэрхийлэгдсэн. Санхүүгийн түрээсийн авлагын хүлээн аваагүй санхүүгийн орлого нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3,200,679 мянган төгрөг (2024: 6,403,428 мянган төгрөг) байна.

**ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК****Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2025 оны 12 дугаар сарын 31****19. Хөрөнгө ба өр төлбөрийн хугацааны шинжилгээ**

Доорх хүснэгтэд Компаний хөрөнгө, өр төлбөрийг эргэн төлөгдөх эсвэл барагдах хугацаагаарх шинжилгээг харуулсан байна. Тодруулга 18 'Хөрвөх чадварын эрсдэл'-ээс Компаний хямдруулаагүй буюу хорогдуулаагүй гэрээний дагуу төлөгдөх үүргийн дүнг харна уу.

<b>2025 оны 12 сарын 31-нээр</b>	<b>12 сараас доош мян.төг</b>	<b>12 сараас дээш мян.төг</b>	<b>Нийт мян.төг</b>
<b>ХӨРӨНГӨ</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	85,300,004	–	85,300,004
Хугацаатай хадгаламж	–	–	–
Дансны болон бусад авлага	23,167,463	–	23,167,463
Түрээсийн авлага	9,200,973	11,003,097	20,204,070
Бусад хөрөнгө	99	–	99
Үндсэн хөрөнгө	–	1,244,521	1,244,521
Биет бус хөрөнгө	–	2,811	2,811
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>117,668,539</b>	<b>12,250,429</b>	<b>129,918,968</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Дансны болон бусад өглөг	249,226	–	249,226
Орлогын албан татварын өглөг	216,708	–	216,708
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>465,934</b>	<b>–</b>	<b>465,934</b>
<b>НИЙТ</b>	<b>117,202,605</b>	<b>12,250,429</b>	<b>129,453,034</b>
<b>2024 оны 12 сарын 31-нээр</b>			
<b>ХӨРӨНГӨ</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,848,063	–	1,848,063
Хугацаатай хадгаламж	64,044,131	–	64,044,131
Дансны болон бусад авлага	28,781,656	–	28,781,656
Түрээсийн авлага	12,883,790	14,841,618	27,725,408
Бусад хөрөнгө	169	–	169
Үндсэн хөрөнгө	–	1,294,811	1,294,811
Биет бус хөрөнгө	–	3,731	3,731
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>107,557,809</b>	<b>16,140,160</b>	<b>123,697,969</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Дансны болон бусад өглөг	190,838	–	190,838
Орлогын албан татварын өглөг	797,743	–	797,743
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>988,581</b>	<b>–</b>	<b>988,581</b>
<b>НИЙТ</b>	<b>106,569,228</b>	<b>16,140,160</b>	<b>122,709,388</b>

## 20. Бодит үнэ цэний талаарх тодруудга

### Бодит үнэ цэнээр хэмжигддэггүй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр илэрхийлэгдээгүй санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан аргачлал болон таамаглалуудыг доор тайлбарлав.

*Дансны үнэ нь бодит үнэ цэнтэйгээ ойролцоо санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр*

Хөрвөх чадвар сайтай эсвэл нэг жилээс бага хугацаатай санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэ нь тэдгээрийн бодит үнэ цэнтэй ойролцоо байна.

*Тогтмол хүүгийн хувь хэмжээтэй санхүүгийн хэрэглүүрүүд*

Хорогдуулсан өртгөөр хэмжигддэг тогтмол хүүгийн хувь хэмжээтэй санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг анх хүлээн зөвшөөрөх үеийн зах зээлийн хүүгийн түвшинг тухайн үеийн Монгол Улсад бэлэн байгаа ижил төрлийн санхүүгийн хэрэглүүрт санал болгож буй хүүгийн түвшинтэй харьцуулан тодорхойлдог.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ болон тэдгээрийн бодит үнэ цэний (бодит үнэ цэний 2-р түвшний ангилалд хамаарах) зөрүү нь маш бага гэж үзсэн.

## 21. Тайлант хугацааны дараах үйл явдлууд

Тайлангийн өдрөөс хойш гарсан санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүйц үйл явдал гараагүй байна.

## 22. Монгол хэл дээрх орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбаруудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувилбарыг баримтална.